



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2020/3/СТА-ТЭЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn Аудитор: Г.Түвшинзаяа Утас: 260512 Цахим хаяг: tuvshinzayag@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	
2.Аудитын тайлан.....	2
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	5
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3.Менежментийн захидал.....	9
4.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЦЭЦИЙН ДАРГА Н.ЧИНБАТ ТАНАА

2020.04.24 № 1313
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

2.Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Чинбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, санхүүгийн тайланд орлого, зарлага, өглөг, авлагыг бүрэн тусгах, үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллогыг чанартай хийх, дотоод хяналтыг сайжруулах гэсэн зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 05-аас 2020 оны 4 дүгээр сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Түвшинзаяа, гэрээт аудитор Б.Мөнгөнцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн В/253 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхтэй байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.

Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн хуулийг дээдлэх, судалгаанд үндэслэх, төвийг сахих, бие даасан, ил тод байх нь Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа боловч сайжруулах шаардлагатай байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдлийг тодорхойлон, гүйцэтгэлийн үе шатанд 7 чиглэлд 8 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,087.7 сая төгрөгөөс тооцон 61.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг дахин тооцоолоогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,769.4 сая төгрөгөөр буюу 134.7 хувиар өссөн

байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	0.02	0.02	-
Авлага	0.8	3.1	2.3
Бараа материал	29.0	42.7	13.7
Үндсэн хөрөнгө	3,509.4	8,262.8	4,753.4
Нийт хөрөнгө	3,539.2	8,308.6	4,769.4
Өр төлбөр	-	5.4	5.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,539.2	8,303.2	4,764.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,539.2	8,308.6	4,769.4

Авлага дансны эхний үлдэгдэл 0.8 сая төгрөгийн авлагыг барагдуулсан ба тайлант онд ном хэвлүүлэхэд урьдчилж төлсөн зардлын 3.0 сая төгрөгийн авлага, 0.1 сая төгрөгийн бусад авлагын үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 13.7 сая төгрөгөөр өссөн нь түлш, шатах тос материал 8.0 сая төгрөгөөр, бичиг хэргийн материал 3.1 сая төгрөгөөр, аж ахуйн материал 2.6 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,753.4 сая төгрөгөөр өссөн нь KOICA-ийн тусламжаар “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд цахим шүүхийн үйлчилгээний тогтолцоо бий болгох” төслөөс 5,131.3 сая төгрөгийн программ хангамж, тавилга эд хогшил, машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 30 дугаар тогтоолоор 259.6 сая төгрөгийн өртөгтэй 4 ширхэг Хьюндай соната, мөн 130 дугаар тогтоолоор 340.0 сая төгрөгийн өртөгтэй 2 ширхэг Ланд круйзер автомашиныг Засгийн газрын авто баазад балансаас балансад шилжүүлж, үндсэн хөрөнгө буурсан зэргээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэлд 2019 онд үүссэн 5.4 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварын өглөг байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан, 2,714.0 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Нийт төсвөөс 2,214.0 сая төгрөгийг урсгал зардалд, 500.0 сая төгрөгийг хөрөнгийн санхүүжилтийн зардалд зарцуулахаар батлагдсан байна.

Төсвөөс нийт 2,214.0 сая төгрөгийн санхүүжилт бүрэн олгогдож, хөрөнгийн санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 20.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 8 эрсдэлтэй асуудлыг тодорхойлж, 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 176.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 134.1 сая төгрөгийн алдааг залруулж, 17.4 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 9.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 15.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Санхүүгийн тайланд дараах алдааг залруулав.
 - Тайлант хугацаанд худалдан авсан, зарцуулаагүй 8.0 сая төгрөгийн шатахууныг зардалд шууд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэж заасантай нийцэхгүй байна.
 - Харилцах данснаас арилжааны банк дахь жижиг мөнгөн сангийн данс руу нийт 154.2 сая төгрөгийг шилжүүлсэн боловч кассын журналд 45.2 сая төгрөгөөр тусгагдсан бөгөөд 108.9 сая төгрөгийн орлого, зарлагыг кассын журналд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: ... 14.4.5 бүх орлого, 14.4.6 бүх зардал..." гэж заасантай нийцэхгүй байна.
 - Ашиглагдаж байгаа 15.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 1.9 сая төгрөгийн бараа материалыг зардалд шууд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.4-т "Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө" гэж заасантай нийцэхгүй байна.
2. Нийт албан хаагчдын ээлжийн амралтын олговрыг бодохдоо 2019 оны 2 дугаар сарын цалингийн ажлын хоногийг оруулж тооцоогүй, өмнөх жилийн ээлжийн амралтын олговрыг оруулж амралтын мөнгийг буруу, давхардуулан тооцон 17.4 сая төгрөг илүү олгосон нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 166 тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Ээлжийн амралтын олговор тооцох журам"-ын 4-т "Ээлжийн амралтын олговрыг тодорхойлохдоо амралт олгохын өмнөх 12 сарын цалин хөлсний нийлбэрийг 12-т хувааж нэг сарын дундаж цалин хөлсийг гаргах бөгөөд гарсан тоог байгууллага, нэгжид мөрдөж буй ажлын өдрийн тоонд хувааж нэг өдрийн дундаж цалин хөлсийг тооцож гаргана", мөн 7-д "Тухайн ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тодорхойлохдоо өмнөх ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тооцоход оруулсан хугацааны дундаж цалин хөлсийг давхардуулан оруулж тооцохгүй" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3. Өр төлбөрийн эхний үлдэгдэлд тусгагдаагүй, 2013 онд хийгдсэн их засварын ажлын үлдэгдэл 9.5 сая төгрөгийн төлбөрийг барагдуулж, тайлант оны зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ: 14.4.4-т бүх өр төлбөр", 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 15.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тухайн жилийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, тендер шалгаруулалтын ерөнхий мэдээлэл, хөрөнгө оруулалтын 105 мэдээллийг хугацаанд нь, 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 42.4 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 61.8 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлтийг өгч байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Үндсэн хуулийн цэцийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Төсвийн зохицуулалт хийх Сангийн яамны зөвшөөрөлгүй 6.1 сая төгрөгийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан, мөн төсвийн зориулалтыг өөрчлөн урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6 дахь “... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийг буруу төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийг үндэслэлтэй боловсруулж, батлуулах, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.2 Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тайлант оны Хувь хүний орлогын албан татварын тайланг татварын цахим сайтад 2.0 сая төгрөгийн авлагын эхний үлдэгдэлтэй, 6.7 сая төгрөгийн өглөгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнасан ч 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд татварын авлагын эхний үлдэгдэлгүй, 5.3 сая төгрөгийн өглөгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнаж, 1.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ: 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.4-т бүх өр төлбөр, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний

стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасантай мөн үнэн зөв батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлээгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Татварын тайланг санхүүгийн тайлантай уялдуулж зөв тайлагнах, татварын байгууллагад хүсэлт гаргаж тайланг залруулах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.3 Жилийн эцсийн тооллоготой холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгө, бараа материалын жилийн эцсийн тооллогын баримтын бүрдэл дутуу байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4-т Тооллогын комисс дараахь үүрэгтэй: 3/ “агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Үндсэн хөрөнгө, бараа материал алга болох, шамшигдах

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллогыг чанартай гүйцэтгэж, бүртгэл, тооцоог цаг хугацаанд нь хийх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно

3.4 Цалингийн зардал

3.4.1 Илрүүлэлт:

Тайлант онд ажиллагсдын ээлжийн амралтаа биеэр эдлээгүй нөхөн олговор тооцохдоо сарын үндсэн цалингаас бус, нийт цалингаас буруу тооцоолж 3.1 сая төгрөг олгосон, цэцийн гишүүнд үндэслэлгүй 2.9 сая төгрөгийн урамшуулал олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.9-д “ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох”, 51 дүгээр зүйлийн 51.1.4-т “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Цалингийн тооцооллыг буруу тооцож, үндэслэлгүй олгосон байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Ээлжийн амралтаа биеэр эдлээгүй нөхөн олговрыг тооцохдоо үндсэн цалингаас тооцож байх, урамшууллыг олгохдоо ажлын үр дүнг дүгнэж байх

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,861.0	45,850.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20.8	20.8
33	АВЛАГА	798.9	3,114.8
35	БАРАА МАТЕРИАЛ	29,041.4	42,714.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,509,366.7	8,262,806.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,509,366.7	8,262,806.1
392	Биет хөрөнгө	3,444,153.4	6,927,873.0
393	Биет бус хөрөнгө	65,213.3	1,334,933.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,539,227.8	8,308,656.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	5,387.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,539,227.8	8,303,268.7
51	Засгийн газрын хувь оролцоо	3,539,227.8	8,303,268.7
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,080,671.2	2,080,671.2
512	Хуримтлагдсан үр дүн	-98,732.5	4,665,308.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,557,289.1	1,557,289.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,539,227.8	8,308,656.6

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,032,354.4	7,828,868.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15.0	5,135,093.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,032,339.4	2,693,774.3
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,765,353.2	2,818,207.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,765,353.2	2,481,040.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,515,127.1	2,448,203.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	952,618.7	1,177,936.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,237.1	142,828.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,929.8	50,338.7
2104	Хангамж, бараа материалын зардал	128,753.3	168,709.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	73,515.7	88,495.6
2107	Томилолт, зочны зардал	28,910.9	92,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,833.2	161,524.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	169,328.4	566,371.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250,226.2	32,836.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	337,166.7
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	267,001.2	5,010,661.0
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	246,620.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-246,620.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	267,001.2	4,764,041.0

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,032,354.4	2,693,824.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15.0	50.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,032,339.4	2,693,774.3
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,691,352.0	2,066,326.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,691,352.0	2,066,326.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,441,110.8	1,985,082.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	951,264.1	1,127,170.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,151.6	139,869.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,929.8	50,338.7
2104	Хангамж, бараа материалын зардал	124,441.8	185,206.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	75,159.7	89,644.6
2107	Томилолт, зочны зардал	28,910.9	100,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,505.2	156,243.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,747.7	136,609.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250,241.2	81,243.8
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	341,002.4	627,498.4
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	341,002.4	627,498.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	341,002.4	627,498.4
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-341,002.4	-627,498.4
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20.8	20.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20.8	20.8

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,656,280.2	-	-	1,656,280.2
2	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	1,550,733.1	-	-	1,550,733.1
3	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	65,213.3	-	-	65,213.3
4	Тайлант үеийн үр дүн	267,001.2	-	-	267,001.2
5	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,539,227.8	-	-	3,539,227.8
6	Тайлант үеийн үр дүн	4,764,041.0	-	4,764,041.0	4,764,041.0
7	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,303,268.7	-	4,764,041.0	8,303,268.7

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,713,974.3	2,693,774.3	20,200.0	99.3
УРСГАЛ ЗАРДАЛ	2,213,974.3	2,213,974.3	-	100.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,132,765.7	2,132,765.7	-	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,127,170.1	1,127,170.1	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,869.9	139,869.9	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,338.7	50,338.7	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	190,863.3	190,863.3	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	111,164.7	111,164.7	-	100.0
Томилолт, зочны зардал	100,000.0	100,000.0	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	276,765.0	276,765.0	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	136,594.0	136,594.0	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,208.6	81,208.6	-	100.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,849.0	2,849.0	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	78,359.6	78,359.6	-	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	500,000.0	479,800.0	20,200.0	96.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,713,974.3	2,693,774.3	20,200.0	99.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,713,974.3	2,693,774.3	20,200.0	99.3
Улсын төсвөөс санхүүжих	2,713,974.3	2,693,774.3	20,200.0	99.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	20.8	20.8	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	20.8	20.8	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	41	41	-	100.0
Удирдах ажилтан	-	-	-	
Гүйцэтгэх ажилтан	41	41	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	41	41	-	100.0
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	9	9	-	100.0
Ажлын албаны албан хаагч (АА)	27	27	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5		100.0

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит.	Аудитын код:
2020/04/25			САГ-2020/3/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол Улсын Үндсэн хуулийн цэц		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл		Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Албан тушаал	Овог нэр
A	3	4	5		9	10
1	Төсвийн зохицуулалт хийх Сангийн яамны зөвшөөрөлгүй 6.1 сая төгрөгийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан, мөн төсвийн зориулалтыг өөрчлөн урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн	6.1	Зөвлөмж өгөх	2020/04/25	Тамгын дарга Ахлах Нягтлан бодогч	Д.Баянбилэг, Б.Эрдэнэбат
2	Өр төлбөрийн эхний үлдэгдэлд тусгагдаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй 2013 онд хийгдсэн их засварын ажлын үлдэгдэл 9.5 сая төгрөгийн төлбөрийг барагдуулсан.	9.5	Албан шаардлага өгөх	2020/04/25	Тамгын дарга Ахлах Нягтлан бодогч	Д.Баянбилэг, Б.Эрдэнэбат
3	Тайлант хугацаанд цалингаас суутгасан Хүн амын орлогын албан татварын тайланд цахим сайтанд 2 сая төгрөгийн авлагын эхний үлдэгдэлтэй, 6.7 сая төгрөгийн өглөгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнасан ч Үндсэн хуулийн цэцийн 2019 оны жилийн эцсийн санхүү байдлын тайланд эхний үлдэгдэлд 2 сая төгрөгийн татварын авлагыг тусгаагүй жилийн эцэст 5.3 сая төгрөгийн өглөг тусгаж, 1.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.	3.4	Зөвлөмж өгөх	2020/04/25	Тамгын дарга Ахлах Нягтлан бодогч	Д.Баянбилэг, Б.Эрдэнэбат
4	Нийт албан хаагчдын ээлжийн амралтын олговрыг бодохдоо 2019 оны 2 дугаар сарын цалингийн ажлын	17.4	Төлбөрийн акт тогтоох	2020/04/25	Тамгын дарга Ахлах	Д.Баянбилэг, Б.Эрдэнэбат

	хоногийг оруулж тооцоогүй, өмнөх жилийн ээлжийн амралтын олговрыг оруулж амралтын мөнгийг буруу, давхардуулан тооцон 17.4 сая төгрөг илүү олгосон				Нягтлан бодогч	
5	Тайлант онд ажиллагсдын ээлжийн амралтаа биеэр эдлээгүй нөхөн олговор тооцохдоо сарын үндсэн цалингаас бус, нийт цалингаас буруу тооцоолж 3.1 сая төгрөг олгосон, цэцийн гишүүнд үндэслэлгүй 2.9 сая төгрөгийн урамшуулал олгосон.	6.0	Зөвлөмж өгөх	2020/04/25	Тамгын дарга Ахлах Нягтлан бодогч	Д.Баянбилэг, Б.Эрдэнэбат
6	Үндсэн хөрөнгө мөн бараа материалын жилийн эцсийн тооллогын баримтын бүрдэл дутуу байна.	-	Зөвлөмж өгөх	2020/04/25	Тамгын дарга Ахлах Нягтлан бодогч	Д.Баянбилэг, Б.Эрдэнэбат
Нийт		42.4				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 04 дугаар сарын 23

№ 04/89

Улаанбаатар хот

САГ- 2020/3/СТА-ТЭЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Нийт албан хаагчдын ээлжийн амралтын олговрыг бодохдоо 2019 оны 2 дугаар сарын цалингийн ажлын хоногийг оруулж тооцоогүй, өмнөх жилийн ээлжийн амралтын олговрыг оруулж амралтын мөнгийг буруу, давхардуулан тооцон 17,457,651.0 (Арван долоон сая дөрвөн зуун тавин долоон мянга зургаан зуун тавин нэг) төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 166 тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Ээлжийн амралтын олговор тооцох журам"-ын 4-т "Ээлжийн амралтын олговрыг тодорхойлохдоо амралт олгохын өмнөх 12 сарын цалин хөлсний нийлбэрийг 12-т хувааж нэг сарын дундаж цалин хөлсийг гаргах бөгөөд гарсан тоог байгууллага, нэгжид мөрдөж буй ажлын өдрийн тоонд хувааж нэг өдрийн дундаж цалин хөлсийг тооцож гаргана", мөн 7-д "Тухайн ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тодорхойлохдоо өмнөх ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тооцоход оруулсан хугацааны дундаж цалин хөлсийг давхардуулан оруулж тооцохгүй" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ээлжийн амралтын мөнгийг буруу, давхардуулан олгосон 17,457,651.0 (арван таван сая хоёр зуун ерэн долоон мянга хоёр зуун далан нэг) төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2020 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тамгын газрын дарга Д.Баянбилэг, ахлах нягтлан бодогч Б.Эрдэнэбат нарт даалгав.

ТОГТООСОН:
 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
 ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 Ц.НАРАНЧИМЭГ
 АУДИТОР Г.ТҮВШИНЗАЯА

АКТ

ЗӨВШӨӨРСӨН:
 МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
 ЦЭЦИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
 Д.БАЯНБИЛЭГ
 НИЯГТЛАН БОДОГЧ
 Б.ЭРДЭНЭБАТ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харгучагч албан тушаалтныг харгучлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kherep\Akt\2020\0423SAG1.Docx

001090266



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 04 дугаар сарын 23

№ 01/206

Улаанбаатар хот

САН 20 20/3/СТА-ТЭЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Өр төлбөрийн эхний үлдэгдэлд тусгагдаагүй 2013 онд хийгдсэн их засварын ажлын үлдэгдэл 9.5 сая төгрөгийн төлбөрийг барагдуулж тайлант оны зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ", 14.4.3-т "бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 12-т заасан "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах;

2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тамгын газрын дарга Д.Баянбилэг, ахлах нягтлан бодогч Б.Эрдэнэбат нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ТОГТООСОН:

САНХҮҮ АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

 Г.ТҮВШИНЗАЯА

ЗӨВШӨӨРСӨН:

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЦЭЦИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

 Д.БАЯНБИЛЭГ

АХЛАХ НИЯГТЛАН БОДОГЧ

 Б.ЭРДЭНЭБАТ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kheree\Alban_Shaardlaa\2020\0423SAG1.Docx

001080732